



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан

МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ /ДОА-2019/38-ГА/



**Зорилт, төлөвлөгөөний хэрэгжилт,
хүний нөөцийн бодлого төлөвлөлт хангалтгүй байна.**

Чойбалсан хот

2019 он



2019.06.12

Мэргэжлийн хяналтын газрын үйл ажиллагааны
хэрэгжилт, үр дүн, үр нөлөө

Тайланг бэлтгэсэн:
Дорнод аймаг дахь Төрийн
аудитын газрын
Гүйцэтгэлийн аудитын
алба

Дарга бөгөөд Тэргүүлэх
аудиторын албан үүргийг
түр орлон гүйцэтгэгч
Ц.Батбаяр
Утас: 70584203

Хэлтсийн дарга бөгөөд
аудитын менежер
В.Цэнгэлмаа
Утас: 70584204

Ахлах аудитор
Б.Дэлгэрмаа,

Аудитор
Я.Зориг
С.Энхбаатар
Утас: 70584207

2019 оны 06 дугаар сар

Аудитын тайлантай
холбоотой асуудлаар
нэмж тодруулах, асууж
лавлах зүйл байвал
70584207, 70584204
дугаарын утас болон
dornod@audit.gov.mn
цахим хаягаар
харилцана уу.

Хаяг: Дорнод аймаг,
Хэрлэн сум, 7-р баг,
аймгийн ЗДТГ-ын 2-р байр,
2 давхар 04 тоот

Агуулга

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

I Бүлэг. Зорилт, төлөвлөгөөний хэрэгжилт, хүний нөөцийн бодлого төлөвлөлт хангалтгүй байна.

1.1. Газрын үйл ажиллагааны төлөвлөгөө, зорилго зорилт бүрэн биелээгүй, байцаагч нарын үйл ажиллагааны үр дүн хангалттай хэмжээнд хүрэхгүй байна.

1.2. Тус газрын бүтэц, орон тоо нь батлагдсан хязгаараас хэтрээгүй боловч зарим хэлтсийн орон тоо нь илүү болон дутагдалтай байна.

II Бүлэг. Батлагдсан төсвийг зарцуулахад анхаарах асуудал байна.

2.1. Орлогын төлөвлөгөөг хэрэгжүүлж ажилласан байна.

2.2. Урсгал зардлаас үндсэн хөрөнгө бэлтгэсэн байна.

III Бүлэг. Дотоод хяналтын үйл ажиллагаа хангалтгүй байна.

3.1. Газрын үйл ажиллагаанд дотоод болон хөндлөнгийн хяналтын тогтолцоо бүрдсэн байна.

3.2. Дотоод хяналтын үйл ажиллагаа хангалтгүй байна.

ДҮГНЭЛТ
ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН
ИРҮҮЛСЭН ХАРИУ
ЗӨВЛӨМЖ
ТУШААЛ
АЛБАН ШААРДЛАГА



ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

УИХ	Улсын Их Хурал
ГА	Гүйцэтгэлийн аудит
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
ГАГ	Гүйцэтгэлийн аудитын газар
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЭМБХХХ	Эрүүл мэнд, боловсрол, хүнсний хяналтын хэлтэс
БОДБХХХ	Байгаль орчин, дэд бүтэц, хөдөлмөрийн хяналтын хэлтэс
ЭИХХЦХХ	Экспорт, импорт, хилийн хорио цээрийн хяналтын хэлтэс
ХУБ	Хяналтын улсын байцаагч
БХА	Бичиг хэргийн ажилтан
ХЦХУБ	Хорио цээрийн хяналтын улсын байцаагч
БО	Байгаль орчин
ҮА	Үйл ажиллагаа
ЭАХХХУБ	Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч
УХХЦХУБ	Ургамал хамгаалал, хорио цээрийн хяналтын улсын байцаагч
МЭХУБ	Мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч
ТЗЭУХ	Төрийн захиргаа, эрсдэлийн удирдлагын хэлтэс
УУХУБ	Уул уурхайн хяналтын улсын байцаагч



Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аудитыг МУЕА-ын орлогчийн “Үндэсний аудитын газрын 2019 онд гүйцэтгэх аудитын сэдэв батлах тухай” 2019 оны А/03 дугаар тушаалыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 15.2-т заасан Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Аудитын зорилт:

Мэргэжлийн хяналтын газрын үйл ажиллагааны хэрэгжилтэд аудит хийж, дүгнэлт өгч, гарсан зөрчлийг арилгах, цаашид сайжруулах, санал, зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэхэд аудитын зорилт чиглэгдлээ. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- *Мэргэжлийн хяналтын газрын удирдлага, зохион байгуулалт үр дүнтэй эсэх,*
- *Мэргэжлийн хяналтын газрын орлогын төвлөрүүлэлт, хөрөнгө, санхүүгийн зарцуулалт үр нөлөөтэй эсэх,*
- *Мэргэжлийн хяналтын газрын үйл ажиллагаанд тавьж байгаа дотоод болон хөндлөнгийн хяналт үр нөлөөтэй эсэх.*

Аудитын хамрах хүрээ:

Аудитыг аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2018 оны үйл ажиллагааны тайлан, төлөвлөгөө, дотоод болон хөндлөнгийн хяналт хийсэн баримт, санхүүгийн баримт, бусад холбогдох материалуудад тулгуурлан гүйцэтгэлээ.

Үндсэн мэдээлэл:

Аймгийн Мэргэжлийн хяналтын газар нь 68 ажиллагсадтай, 5 нэгжтэй, 2018 онд улсын төсвийн санхүүжилтээр 915,6 сая төгрөг, өөрийн орлогоор 123,5 сая төгрөг, орон нутгийн төсвөөр 19,9 сая төгрөгийн нэмэлт орлого, нийт 1059,0 сая төгрөгийн батлагдсан төсөвтэй үйл ажиллагаа явуулсан байна.

Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхдээ Гүйцэтгэлийн аудитын удирдамж, (АДБОУС 3000-3100, Гүйцэтгэлийн аудитын гарын авлага, журамд заасны дагуу холбогдох албан тушаалтантай ярилцлага хийх, тайлбар, тодруулга, шалгагдагч байгууллагаас авсан судалгаа, мэдээлэл, нотлох зүйлсийг нягтлан шалгах, дүн шинжилгээ хийх, тулган баталгаажуулах, анхны баримтаас хөөн шалгах зэрэг аудитын горимуудыг ашиглав.

Аудитын шалгуур үзүүлэлт:

Аудитад дараах хууль эрхийн актыг шалгуур үзүүлэлт болголоо.

- *Төрийн албаны тухай хууль*



- Төсвийн тухай хууль
- Төрийн хяналт шалгалтын тухай хууль
- Зөрчлийн тухай хууль
- Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Холбогдох бусад хууль, журам, хууль эрхийн актууд

Аудит хийх багийн бүрэлдэхүүн:

Аудитыг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудиторын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Батбаяр удирдаж, үе шатны болон чанарын хяналтыг аудитын менежер В.Цэнгэлмаа хэрэгжүүлж, гүйцэтгэлийн аудитын албаны ахлах аудитор Б.Дэлгэрмаа, аудитор Я.Зориг, С.Энхбаатар нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ.

Аудитын хугацаа:

Аудитын төлөвлөлтийн үе шатны ажлыг 04 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлүүлэн тайланг 06 дугаар сарын 25-ны өдөр дуусган Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн холбогдох байгууллагуудад хүргүүлэв.

Аудитын тайлангийн бүтэц түүнд тусгагдах мэдээлэл, хэлэлцүүлэх журам

Аудитын тайлан нь оршил хэсэг, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж, холбогдох газрын санал, түүнд өгсөн тайлбар гэсэн хэсгүүдээс бүрдэх бөгөөд аудитын дэд зорилтын дагуу бичлээ. Аудитын тайлангийн төслийг шалгагдагч байгууллагын удирдлагад танилцуулж санал авсан бөгөөд тайлангийн эцсийн хувилбарыг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн дарга бөгөөд Тэргүүлэх аудиторын тушаалаар баталгаажууллаа.



I Бүлэг. Зорилт, төлөвлөгөөний хэрэгжилт, хүний нөөцийн бодлого төлөвлөлт хангалтгүй байна.

1.1. Газрын үйл ажиллагааны төлөвлөгөө, зорилго зорилт бүрэн биелээгүй, байцаагч нарын үйл ажиллагааны үр дүн хангалттай хэмжээнд хүрэхгүй байна.

Мэргэжлийн хяналтын газар нь 2018 онд 9 зорилтын хүрээнд 82 ажлыг хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөө боловсруулж, МХЕГ-ын даргаар батлуулсан байна. Үүнд:

2018 онд дэвшүүлсэн зорилт:

1. Хүнсний сүлжээний бүх үе шатанд эрсдэлээс урьдчилан сэргийлж, эрсдэлийг бууруулах замаар хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг хангуулна.
2. Олон улсын хүний хөл хориот, малын гоц халдварт өвчин, ургамлын хорио цээртэй зүйлс хил дамжин тархах халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах чадавхыг сайжруулах, импорт, экспортын барааны аюулгүй байдлыг хангах, гадаад худалдаа эрхлэгч аж ахуйн нэгж, иргэдэд зөвлөмж, мэдээллийг хүртээмжтэй түгээх, хилийн боомтын хяналт шалгалт явуулах хэвийн нөхцөлийг бүрдүүлнэ.
3. Нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангуулах замаар хүний аюулгүй байдлыг хангаж, иргэнийг сурч боловсрох тэгш боломж, чанартай боловсрол эзэмших нөхцөлийг бүрдүүлэн, соёлын өвийн хадгалалт хамгаалалт, хуулийн хэрэгжилтийг сайжруулна.
4. Байгалийн нөөц баялгийн зохистой ашиглалтыг сайжруулж, хүний хүчин зүйлээс шалтгаалсан байгаль орчны бохирдол, доройтлыг бууруулна.
5. Аюулгүй орчинд хөдөлмөрлөх, үйлдвэрлэлийн осол гэмтэл, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх, хөдөлмөр эрхлэлт болон даатгуулагчдын нийгмийн баталгааг хангуулна.
6. Барилга байгууламж, техник, тоног төхөөрөмжийн зураг төсөл, угсралт, ашиглалтын аюулгүй ажиллагааг хангуулах замаар нийтийн аюулгүй байдлыг хангуулна.
7. Цөмийн болон цацрагийн аюулгүй байдлыг хангуулж, болзошгүй цацрагийн ослоос урьдчилан сэргийлнэ.
8. Хяналтын итгэмжлэгдсэн сүлжээ лабораторийн үйл ажиллагааг өргөжүүлж, хүнс болон эмийн аюулгүй байдлыг хангуулна.
9. Мэргэжлийн хяналтын байгууллагын үйл ажиллагааны үр дүнтэй байдлыг дээшлүүлэх, цахим системийг хөгжүүлж, хүртээмжийг нэмэгдүүлнэ.

Тус газраас төлөвлөгөөний биелэлтийг 83,6 хувийн биелэлттэй гэж тайлагнасан байна. Аудитын явцад дээрх зорилтуудын хэрэгжилтийг тооцож үзэхэд 79,6 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт №1. "Төлөвлөгөөний биелэлтэд хийсэн шинжилгээ"

Зорилт	Заалтын тоо	Хамааралгүй заалт	Хэрэгжсэн заалтын тоо	Хувь	Тайлбар
Нэг	9	-	7,6	84,4	
Хоёр	14	-	11,5	82,1	
Гурав	8	-	5,9	73,7	
Дөрөв	8	-	6,6	82,5	
Тав	7	-	6,2	88,6	
Зургаа	6	-	5,5	91,7	
Долоо	8	1	5,6	80	
Найм	8	-	5,5	68,7	Дэвшүүлсэн зорилтын биелэлт дутуу, байхгүй.
Ес	14	-	9,1	65	Дэвшүүлсэн зорилтын биелэлт дутуу, байхгүй.
НИЙТ	82	1	63,5	79,6	



Аймгийн МХГ-ын байцаагч нарын ажлын үр дүнг үнэлэхдээ үйл ажиллагааны төлөвлөгөө, үр дүнгийн гэрээний биелэлт, тайланг үндэслэн үнэлэлт, дүгнэлт өгсөн байна. Байцаагч нарын 2018 оны үр дүнг дараах байдлаар дүгнэсэн байна.

Хүснэгт №2. "Аймгийн МХГ-ын байцаагчдын 2018 оны үр дүнгийн гэрээний биелэлт"

№	Хэлтэс	Гэрээ дүгнүүлсэн байцаагчдын тоо	Үнэлгээ /хувиар/	Тайлбар
1	ЭМБХХХ	10	83-93,0	5 нь А, 5 нь В
2	БОДБХХХ	13	80-98,7	7 нь А, 6 нь В
3	ЭИХХЦХХ	13	81-91,9	8 нь А, 5 нь В
Нийт		36	80-98,7	20 нь А, 16 В

БОДБХХХ-ийн байцаагчдын үр дүнгийн гэрээний үнэлгээ 80,0- 98,7 хувь хүртэл дүгнэгдсэн байна. Үүнээс авто замын хяналтын улсын байцаагчийн үр дүнгийн гэрээний биелэлт 81,1, барилын техникийн хяналтын улсын байцаагчийн үр дүнгийн гэрээний биелэлт 92,0 хувьтай байгаа хэдий ч зарим улсын болон орон нутгийн чанартай авто зам, барилга, байгууламжид хийгдсэн хяналт шалгалт дутмаг байна.

Тухайлбал: Улс, орон нутгийн 2018 оны төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд хийгдсэн зам, барилга, байгууламжийн ажлуудын гүйцэтгэлийн хяналтын материалыг үзэж шалгах явцад ажил хүлээж авах улсын комиссын бүрэлдэхүүнд ажилласан боловч гүйцэтгэлийн хяналтыг хэрэгжүүлсэн эсэх нь нотлогдохгүй байна. Харин хүлээж авах улсын комиссын бүрэлдэхүүнд ажилласан байна.

Авто замын хяналтын хувьд хөдөө, орон нутгийн хайрган болон шороон хучилттай зам, зарим уул, уурхайн компаниудын зам ашиглалт, норм нормативын байдалд хяналт тавьсан тухай тайланд дурдагдсан байна. Өнгөрсөн жилийн хувьд Чойбалсан хотын 10 дугаар багийн гэр хороололд бетонон зам тавих ажилд хяналт шалгалтыг хэрэгжүүлж, бусад авто замын сангаар хэрэгжүүлсэн ажилд хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

ЭИХХЦХХ-ийн байцаагчдын 2018 оны үр дүнгийн гэрээ 81,0-91,9 хувийн үнэлгээтэй байгааг бусад хэлтсийн үйл ажиллагаатай харьцуулахад ажлын үр дүн, хамрах хүрээ харьцангуй бага байна.

Энэ нь нэг талаас хэлтэст сул орон тоо их, хөдөө орон нутагт ажиллах хүн олддоггүй, нэг байцаагчид ногдох ажлын ачаалал их байгаатай холбоотой байна.

Аймгийн МХГ-ын дарга, МХЕГ-ын даргатай 2018 онд байгуулсан үр дүнгийн гэрээг 89,3 хувь, аймгийн Засаг даргатай байгуулсан үр дүнгийн гэрээ 88,0, аймгийн ЗДТГ-ын ажлын хэсгийн гаргасан бодлогын баримт бичгийн хэрэгжилт /хөтөлбөр, хууль, тогтоомж, зорилго зорилт гэх мэт/ 92,5 хувьтай тус тус дүгнэгдсэн байна.

Улсын хэмжээнд 2018 оноос эхлэн мэргэжлийн хяналтын байгууллагын үйл ажиллагаа, үр дүнгийн талаар www.khyanal.gov.mn цахим сайтаар дамжуулан хэрэглэгч болон дотоод хэрэгцээнд зориулан ашиглаж эхэлсэн байна. Тус цахим сайтад байршуулсан мэдээллээр улсын хэмжээнд 2018 оны албан шаардлагын биелэлт, гүйцэтгэлийн хяналтыг хэрэгжүүлсэн байдал 11,0 хувь, аймгийн хувьд 20,0 хувьтай гарсан байна.

Бид аудитын явцад 22 байцаагчийн 2018 онд хийсэн төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтын үр дүнг түүвэрлэж үзсэн бөгөөд энэ нь нийт



2019.06.12

**Мэргэжлийн хяналтын газрын үйл ажиллагааны
хэрэгжилт, үр дүн, үр нөлөө**

байцаагчдын 60,0 хувь, аймгийн төв дээр ажиллаж байгаа байцаагчдын 80,0 хувийг эзэлж байна.

МХГ-аас хяналт шалгалт хийгдсэний дараа акт, албан шаардлага, зөвлөмж, торгууль тавигддаг бөгөөд үүнээс акт, торгууль биелсэн бол зөвлөмж, албан шаардлагыг албан бичгээр тооцдог байна.

Хүснэгт №3. "Албан шаардлагын биелэлт, гүйцэтгэлийн хяналт"

№	Хэлтэс, байцаагчид	Төлөвлөгөөт		Албан шаардлага			Тайлбар
		Төлөвлөсөн	Шалгасан	Үйлдсэн тоо	Заалт	Биелэлт, Гүйцэтгэлийн хяналт	
Эрүүл мэнд, боловсрол, хүнсний хяналтын хэлтэс							
1	Эрүүл ахуй, халдвар хамгааллын ХУБ	29	26	16	112	80 хувь	3 объект ҮА явуулаагүй.
2	Эрүүл ахуй, халдвар хамгааллын ХУБ	18	18	16	98	70 хувь	
3	Мал эмнэлгийн ХУБ	13	12	12	142	72 хувь	1 объект ҮА явуулаагүй.
4	Боловсролын ХУБ	11	11	11	41	65 хувь	
5	Соёлын ХУБ	9	9	8	24	21 хувь	
6	Эм биобэлдмэлийн ХУБ	17	17	11	90	90 хувь	
7	Таримал ургамлын үр, хорио цээрийн ХУБ	9	9	13	153	65 хувь	
8	Эмчилгээний чанарын ХУБ	11	11	14	137	85,4 хувь	
9							
10							
	Нийт дундаж	117	113	101	797	68,5 хувь	
Байгаль орчин, дэд бүтэц, хөдөлмөрийн хяналтын хэлтэс							
1	Байгаль орчны ХУБ	17	12	11	10	70 хувь	5 газар ҮА явуулаагүй.
2	Цөмийн болон цацрагийн ХУБ	5	5	2	30	0 хувь	
3	Хөдөлмөрийн ХУБ	4	4	6	51	66,6 хувь	
4	Нийгмийн хамгааллын ХУБ	10	9	7	52	100 хувь	1 газар ҮА явуулаагүй.
5	Байгаль орчны ХУБ	10	6	2	10	100 хувь	4 газар ҮА явуулаагүй.
6	Байгаль орчин, газар, геодези, зурагзүйн ХУБ	16	12	7	28	71,1 хувь	4 газар ҮА явуулаагүй.
7	Барилгын техникийн ХУБ	14	13	16	82	25 хувь	1 газар ҮА явуулаагүй.
8	Автозамын ХУБ	9	8	3	12	33 хувь	1 газар ҮА явуулаагүй.
9	Эрчим хүчний ХУБ	17	16	3	9	30 хувь	1 газар ҮА явуулаагүй.
10	Хэмжил зүйн ХУБ	16	12	3	16	81,2 хувь	4 газар ҮА явуулаагүй.
11	Хөдөлмөрийн эрүүл ахуйн ХУБ	8	7	12	71	71 хувь	1 газар ҮА явуулаагүй.
	Нийт дундаж	126	104	72	371	58,9 хувь	



Экспорт, импорт, хилийн хорио цээрийн хяналтын хэлтэс						
1	Мал эмнэлгийн ХУБ	13	13	13	108	100 хувь
2	Хүнсний чанар, стандартын ХУБ	0	128	5	3	100 хувь
3	Ургамал, хорио цээрийн ХУБ					
	Нийт дундаж	13	141	191	121	100 хувь
	НИЙТ БҮГД	256	358	364	1289	75,8 хувь

- ЭИХХЦХХ-ийн байцаагч нарын хувьд 2018 онд чиг үүргийнхээ дагуу ургамал, хорио цээр, хүнсний чанар стандартын хяналтыг хэрэгжүүлж, хилээр нэвтэрч буй тээврийн хэрэгслээр дамжин орж ирж буй хүнсний бүтээгдэхүүн, ургамалд үзлэг шалгалт хийж, 4 албан шаардлага өгөгдөж, 100 хувийн биелэлттэй, ААН, иргэдэд зөвлөн тусалж, зөрчилд торгуулийн арга хэмжээ авсан байна.
- ЭМБХХХ-ийн 8 байцаагч 2018 онд 797 заалттай 101 албан шаардлага өгч, 68,5 хувийн биелэлттэй байна.
- БОДБХХХ-ийн 11 байцаагч 2018 онд 371 заалттай 104 албан шаардлага өгч, 58,9 хувийн биелэлттэй байна.

Улсын болон аймгийн хэмжээнд гүйцэтгэлийн хяналтын хэрэгжилт доогуур үзүүлэлттэй байгаа нь шинээр цахим систем нэвтэрсэнтэй холбогдуулан байцаагчид шивэлтийг тухай бүрд шивж оруулаагүйтэй холбоотой байна. Нөгөө талаас салбарын хэмжээнд гүйцэтгэлийн хяналтын зардал батлагддаггүй, техник, хүний нөөцийн хүрэлцээгүй байдал, ажлын ачаалал их байгаатай холбоотойгоос газар дээр нь үзэж шалгах ажлууд орхигдсон байна.

Хэдийгээр шилэн хяналтын систем дэх аймгийн МХГ-ын байцаагч нарын албан шаардлагын биелэлт буюу гүйцэтгэлийн хяналтын хувь нь маш хангалтгүй үзүүлэлттэй байгаа боловч бодит байдал дээр байцаагч нарын 2018 оны гүйцэтгэлийн хяналтын үр дүн нь 75,8 хувьтай байна. Энэ нь хангалттай үзүүлэлт биш тул цаашид гүйцэтгэлийн хяналтыг сайжруулах, албан шаардлагын биелэлтийг газар дээр нь үзэж шалгах, тулган баталгаажуулалт хийж байх шаардлагатай байна.

Цаашид хэлтсүүдийн хяналт шалгалтын хамрах хүрээ, төлөвлөгөөт шалгалтуудаас гадна, улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй барилга, байгууламж, авто замын ажлуудад төлөвлөгөөт бус хяналт шалгалтын тоог нэмэгдүүлж, үр дүнг сайжруулах, эрсдэлийг төлөвлөхдөө орон нутгийн удирдлагатай зөвшилцөж иргэдийн хүлээлттэй байгаа асуудалд анхаарал хандуулах нь зүйтэй байна.


1.2. Тус газрын бүтэц, орон тоо нь батлагдсан хязгаараас хэтрээгүй боловч боловч зарим хэлтсийн орон тоо нь илүү болон дутагдалтай байна.

Аймгийн Мэргэжлийн хяналтын газар нь 2019 онд МХЕГ-ын даргын 2019 оны А/05 дугаар тушаалаар 72 орон тоотой байхаар батлагдаж, гүйцэтгэлээр 64 орон тоотой ажилласан байна.




Албан хаагчдын статистик мэдээлэл:

Дүрслэл №1. “Албан хаагчдын хүйс, боловсролын судалгаа”



Нийт албан хаагчдын 66,0 хувь нь эмэгтэй, 88,0 хувь нь дээд буюу бакалаврын боловсрол эзэмшсэн албан хаагчид байна.

Дүрслэл №2. “Албан хаагчдын ажилласан жилийн судалгаа”



Дээрх шинжилгээнээс харахад албан хаагчдын 50-иас дээш хувь нь 5-аас дээш жил ажилласан, ажлын дадлага, туршлагатай албан хаагчид байна.

Хүснэгт №4. “Бүтэц, орон тооны шинжилгээ”

№	Хэлтэс	Батлагдсан орон тоо	Одоогийн орон тоо	Тайлбар
Төрийн захиргаа, эрсдэлийн удирдлагын хэлтэс				
1	Газрын дарга	1	1	
2	ТЗЭУХ-ийн дарга	1	1	



3	Хүний нөөц, эрх зүйн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн	1	1	
4	Нягтлан бодогч	1	1	
5	Архив, БХА	1	1	
6	Нярав	1	1	
7	Бусад үйлчилгээний ажилтан	3	5	
	Дүн	9	11	2 орон тоо илүү
Эрүүл мэнд, боловсрол, хүнсний хяналтын хэлтэс				
1	Боловсролын ХУБ	1	1	
2	Соёлын ХУБ	1	1	
3	Эмчилгээний чанарын ХУБ	1	1	
4	Эм биобэлдмэлийн ХУБ	1	1	
5	Эрүүл ахуй, халдвар хамгааллын ХУБ	3	3	
6	Хүнсний чанар, стандартын ХУБ	1	2	
7	Мал эмнэлгийн ХУБ	2	2	
8	Мал үржлийн ХУБ	1	1	
9	Ургамал хамгаалал, ХЦХУБ	1	1	
10	Таримал ургамлын үр, ХЦХУБ	1	1	
	Дүн	13	14	1 орон тоо илүү
Байгаль орчин, дэд бүтэц, хөдөлмөрийн хяналтын хэлтэс				
1	Барилгын техникийн ХУБ	1	1	
2	Эрчим хүчний ХУБ	1	1	
3	Авто тээврийн ХУБ	1	1	
4	Авто замын ХУБ	1	1	
5	Хэмжил зүйн ХУБ	1	1	
6	Нийгмийн хамгааллын ХУБ	1	1	
7	Хөдөлмөрийн ХУБ	2	2	1 хүн тэтгэвэрт гарч оронд нь хүн аваагүй, хавсран гүйцэтгэдэг.
8	Хөдөлмөрийн эрүүл ахуйн ХУБ	1	1	
9	Байгаль орчны ХУБ	3	3	
10	Цөмийн болон цацрагийн ХУБ	1	1	
11	БО, газар, геодези, зураг зүйн ХУБ	1	1	
12	Геологи, УУХУБ	1	1	
	Дүн	15	15	
Экспорт, импорт, хилийн хорио цээрийн хяналтын хэлтэс				
1	Хэлтсийн дарга	1	1	
2	ЭАХХХУБ	5	3	1 хүн хүүхэд асрах чөлөөтэй, 1 сул орон тоо
3	УХХЦХУБ	5	4	1 хүн хүүхэд асрах чөлөөтэй
4	МЭХУБ	6	3	1 хүн хүүхэд асрах чөлөөтэй, 2 сул орон тоо
5	Хүнсний чанар СХУБ	3	1	2 сул орон тоо
6	Эм биобэлдмэлийн ХУБ	1	0	1 Тэтгэвэрт гарсан. Оронд хүн аваагүй.
7	БО-ны ХУБ	2	1	1 хүн хүүхэд асрах чөлөөтэй
8	Цөмийн болон цацрагийн ХУБ	1	1	
9	Ариутгагч	5	4	1 хүн хүүхэд асрах чөлөөтэй
	Дүн	29	18	11 орон тоо сул, оронд нь хүн аваагүй.
1	Лабораторийн эрхлэгч, ажилтан	6	6	
	Дүн	6	6	
	НИЙТ ДҮН	72	64	

Бүтэц орон тооны шинжилгээнээс харахад ТЗЭУХ нь 2, ЭМБХХХ нь 1, нийт 3 орон тоо илүү байна.

БОДБХХХ нь 1, ЭИХХЦХХ нь 11, нийт 12 орон тоо дутуу байна. Үүнээс:



ЭИХХЦХХ-ээс 5 хүн хүүхэд асрах чөлөөтэй, БОДБХХХ-ээс 1 хүн, ЭИХХЦХХ-ээс 1 хүн тэтгэвэрт гарч оронд нь хүн аваагүй, ЭИХХЦХХ-ээс 5 хүний орон тоо сул байна.

Шинээр 2019 онд төрийн үйлчилгээ, захиргааны албан тушаалд 5 албан хаагч томилогдсоноос түр орон тооны тушаалтай 2 үйлчилгээний албан хаагч байна.

ТЗЭУХ, ЭМБХХХ-т нийт 3 орон тоогоор илүү байгаа нь МХЕГ-ын даргын баталсан тушаалын бүтэц, орон тооны хязгаараас давсан байна. Бусад 2 хэлтэс нь нийт 12 орон тоогоор дутуу ажиллаж байгаа нь хэлтэс болон газрын дэвшүүлсэн зорилт, үйл ажиллагааны төлөвлөгөө бүрэн хэрэгжихгүй байх, ажлын байрны эзэнгүйдэл үүсэж, нэг байцаагчид ногдох ажлын ачаалал ихсэх эрсдэлийг үүсгэж байна.

Байгаль орчин, дэд бүтэц, хөдөлмөрийн хяналтын хэлтэс, Экспорт, импорт, хилийн хорио цээрийн хяналтын хэлтэст тус бүр 1 албан хаагч тэтгэвэрт гарч, эдгээр ажлын байранд хүн авч ажиллуулаагүй байгаа нь УИХ-ын 2014 оны 147, 2017 оны 29 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангасантай холбоотой байна.

ЭИХХЦХХ-т шаардлагатай байгаа Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч, Байгаль орчны хяналтын улсын байцаагч, Мал эмнэлгийн хяналтын улсын байцаагчийн орон тооны захиалгыг 2019 оны 02 дугаар сард Төрийн албаны зөвлөлийн Дорнод аймаг дахь салбар зөвлөлд хүргүүлсэн боловч орон тооны асуудал одоог хүртэл шийдэгдээгүй байна. Энэ нь дараах шалтгаантай холбоотой байна.

1. Төрийн албаны хууль шинэчлэгдсэнтэй холбогдуулан Төрийн албаны зөвлөлөөс гаргасан албан даалгаврын дагуу нөөцөд бүртгэлтэй иргэдийн тодорхойлолтыг олгохгүй болсон.
2. Нөөцөд байгаа иргэд тухайн ажлын байрны ерөнхий шаардлагыг хангахгүй.
3. Ерөнхий шаардлагыг хангаж байгаа цөөн тооны иргэд нь хөдөө орон нутагт ажиллах сонирхолгүй.
4. Сул орон тооны захиалгын дагуу төрийн жинхэнэ албан хаагчийн мэргэшлийн шалгалтын тов зарлагдаагүй.

Албан тушаал хавсран гүйцэтгэж байгаа болон хяналт шалгалтын цар хүрээ их, орхигдсон салбарыг давхар хариуцдаг дараах ажлын байрууд байна.

Хүснэгт №5. "Албан тушаалын шинжилгээ"

№	Албан тушаалын нэр	Хавсран гүйцэтгэж байгаа албан тушаал	Орхигдсон, давхар гүйцэтгэж байгаа албан тушаал	Тайлбар
1	Захиргаа удирдлагын хэлтсийн дарга	Хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч		Тэтгэвэрт гарсан хүний албан тушаалыг хавсран гүйцэтгэдэг.
2	Эрүүл ахуй халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч		Хүүхдийн эрүүл ахуй, үдийн цай, хоолны чанар, халдвар хамгаалал	Батлагдсан орон тоо байхгүйгээс орхигдсон чиг үүргийг давхар хэрэгжүүлдэг.
3	Барилгын техникийн хяналтын улсын байцаагч		Хот байгуулалт, ерөнхий төлөвлөгөө, барилга	Өмнө нь 2 орон тоо байсан. Хувийн хэвшлийн барилга байгууламжид хийх хяналт шалгалт их,



		байгууламж	улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдсэн ажил бүрд хяналт хийгээгүй байна.
--	--	------------	---

- Дорнод аймгийн хэмжээнд жил ирэх тусам улс, орон нутаг, хувийн хэвшил, төсөл, хөтөлбөрийн хөрөнгө оруулалтаар хийгдэх барилга, байгууламжийн ажлууд нэмэгдсээр байхад газрын хэмжээнд 1 байцаагч ажиллаж байна.
- Дорнод аймгийн хэмжээнд 2018-2019 оны хичээлийн жилд 26 сургуулийн 551 бүлгийн 15445 хүүхэд, 37 цэцэрлэгт 7150 хүүхэд суралцаж байна. Үдийн цай хөтөлбөр хэрэгжиж байгаатай холбогдуулан хүүхдийн үдийн цай, хоолны чанарын асуудалд анхаарал тавих шаардлага үүссэн. Үүнийг дагаж чанарын шаардлага хангахгүй хүнсний бүтээгдэхүүн, цай, хоолоор үйлчлэх, стандарт, норм норматив хангахгүй гал тогоо, өрөө тасалгаагаар үйлчлэх газар, объектын тоо нэмэгдэх хандлагатай байна. Гэтэл газрын хэмжээнд хүүхдийн хоол хүнс, эрүүл ахуйн хяналтын чиглэлээр батлагдсан орон тоо байхгүй байгаа нь өндөр эрсдэлийг дагуулж байна.

Үүний шалтгаанууд нь Мэргэжлийн хяналтын салбарын хэмжээнд хүний нөөцийн бүтэц, орон тооны норматив байхгүй, газрын хэмжээнд хүний нөөцийн бодлогын баримт бичгийн хэрэгжилт хангалтгүй байгаатай холбоотой байна.

Цаашид хэлтсүүд нь МХЕГ-ын даргын 2019 оны А/05 дүгээр тушаалыг баримтлан бүтэц, орон тооны батлагдсан орон тооны хязгаараас давуулахгүй байх, Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийг баримтлан хүүхэд асрах чөлөөтэй болон ажлын байрны сул орон тоог нөхөж ажиллах талаар албан шаардлага өгөгдлөө.

Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам шинэчлэгдсэнтэй холбогдуулан аудитын явцад аймгийн МХГ-ын албан хаагчдын 93,0 хувийг хамруулан хувийн хэрэг хөтлөлттэй танилцсан бөгөөд албан хаагчид ажлын байрны тодорхойлолт, ерөнхий шаардлагад нийцсэн байна.

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 05 дугаар тогтоолд заасны дагуу хувийн хэрэг хөтлөлтийг анкет А, Б хэсэг, нэмэлт хуудас, хувь хүний намтар, төрийн жинхэнэ албаны шалгалт өгснийг нотлох баримт зэрэг шалгуур үзүүлэлтүүдийг нягтлан шалгаж, тулган баталгаажуулсан бөгөөд хувийн хэргийн бүрдүүлэлт, баяжилт хангалттай түвшинд байна.

II Бүлэг. Батлагдсан төсвийг зарцуулахад анхаарах асуудал байна.

2.1. Орлогын төлөвлөгөөг хэрэгжүүлж ажилласан байна.

Аймаг дахь Мэргэжлийн хяналтын газрын төсөв нь дараах орлогуудаас бүрдэж байна. Үүнд:

1. Улсын төсвөөс санхүүжих
2. Төсөвт байгууллагын өөрийн орлого

Төсөвт байгууллагын өөрийн орлого нь ариутгал, халдваргүйтгэлийн хураамж, шинжилгээний орлогоос тус тус бүрдэж байна.



2016-2018 оны өөрийн орлогыг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №6. /сая.төгрөг/

Орлогын нэр төрөл	2016 он			2017 он			2018 он		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлт /хувиар/	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлт /хувиар/	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлт /хувиар/
Өөрийн орлого	60,0	121,3	102,2	69,0	130,2	88,7	90,0	123,5	37,2

Тус газрын өөрийн орлогын төлөвлөлтийг шинжилж үзэхэд МХЕГ-аас орлогын төлөвлөгөөг баталж ирүүлдэг байна. Өөрийн орлогыг 100,0 хувь МХЕГ-ын дансанд төвлөрүүлсэн байна.

Мэргэжлийн хяналтын газрын өөрийн орлого төлөвлөснөөсөө гүйцэтгэлээр 2016 онд 61,3 сая төгрөг, 2017 онд 61,2 сая төгрөг, 2018 онд 33,5 сая төгрөгөөр тус тус давсан байна. Давсан шалтгаан нь Хавирга, Баян-Хошуу боомтууд байнгын ажиллагаатай болж зорчигчдын тоо өссөн зэрэг нь нөлөөлсөн байна.

Аймаг дахь Мэргэжлийн хяналтын газар нь үндсэн үйл ажиллагааны орлогоос гадна хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, зөрчлийг арилгах чиглэлээр хүү, торгуулийн орлогыг төвлөрүүлдэг байна.

МХЕГ-ын 2017 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн баталсан “Мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн шийтгэвэр, торгуулийн хуудас, хяналт шалгалтын баримт бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэх, түүнд хяналт тавих” журмын 4.3 дахь “Шийтгэвэр, торгууль, нөхөн төлбөрийн хуудсаар ногдуулсан мөнгийг хариуцагч этгээдээр Төрийн санд байрлах төсвийн дансанд төвлөрүүлж, баримтыг хавсаргана” гэсэн заалтын дагуу орон нутгийн орлогод төвлөрүүлэн ажилласан байна.

2016-2018 оны хүү, торгуулийн орлогыг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт: №7 /сая.төгрөг/

Орлогын нэр төрөл	2016 он			2017 он			2018 он		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлт /хувиар/	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлт /хувиар/	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлт /хувиар/
Хүү, торгуулийн орлого	25,0	163,2	552,8	25,0	49,4	97,6	183,0	207,8	13,6

Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг аймгийн ИТХ-ын тогтоолоор 183,0 сая төгрөгөөр, 2019 онд 55,0 сая төгрөгөөр тус тус баталсан байна.

Сүүлийн 4 жилийн орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөг шинжилж үзэхэд Мэргэжлийн хяналтын газрын жилийн орлогын хүлээгдэж буй гүйцэтгэл, орлогын дундаж үзүүлэлтийг үндэслэхгүй их зөрүүтэй төлөвлөсөн байгаа нь аймгийн Мэргэжлийн хяналтын газар, аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсийн уялдаа холбоо муу байгааг харуулж байна.

Дээрх төлөвлөсөн дүнгээс 2018 онд 5,8 хувиар буюу 10,6 сая төгрөгөөр давуулан төвлөрүүлсэн байна.

Хүү, торгуулийн орлогын өмнөх онуудын дутуу төлөлт 2018 оны эцэст 73,2



сая төгрөг, үүнээс 2018 оны төлөгдөөгүй үлдэгдэл 14,2 сая төгрөг байснаас 2019 оны 04 дүгээр сарын 25-ны байдлаар нийт үлдэгдэл 5,7 сая төгрөг болж буурсан нь МХЕГ-ын 2019 оны 01/734 тоот албан тоот бичгээр өмнөх онуудын үлдэгдлийг барагдуулах арга хэмжээ авах үүрэг өгсний дагуу авлага барагдуулах ажил зохион байгуулж өмнөх онуудын авлагыг 67,5 сая төгрөгөөр бууруулсан байна.

2.2. Урсгал зардлаас үндсэн хөрөнгө бэлтгэсэн байна.

Дорнод аймгийн Мэргэжлийн хяналтын газар нь 2018 онд 915,6 сая төгрөгийн батлагдсан төлөвлөгөөтэй ажилласнаас гүйцэтгэлээр 910,7 сая төгрөгийн зардал гаргасан байна.

Төсвийн зардлын гүйцэтгэлийг нэр төрлөөр нь харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт №8 “Зардлын судалгаа”, /мянган төгрөг/

Үзүүлэлт	2018 он		Зөрүү	Эзлэх хувь
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	635504,6	635391,1	113,5	69,8
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	76260,5	76260,5	0,0	8,4
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	26492,7	23258,7	3234,0	2,5
Гэрэл, цахилгаан	14263,5	12598,9	1664,6	
Түлш, халаалт	9642,5	8608,4	1034,1	
Цэвэр, бохир ус	2586,7	2051,4	535,3	
Хангамж, бараа материалын зардал	38961,8	38169,0	792,8	4,2
Бичиг хэрэг	7510,7	7554,2	-43,5	
Тээвэр, шатахуун	20894,7	20000,0	894,7	
Шуудан, холбоо, интернетийн төлбөр	7704,7	7173,9	530,8	
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн ариутгал	1020,0	1675,1	-655,1	
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1831,7	1765,8	65,9	
Нормативт зардал	16488,8	16338,2	150,6	1,8
Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	14688,8	15545,6	-856,8	
Хоол, хүнс	1800,0	792,6	1007,4	
Эд хогшил, урсгал засварын зардал	59638,8	59636,7	2,1	6,5
Багаж, техник, хэрэгсэл	23000,0	24404,4	-1404,4	
Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	17400,0	16618,1	781,9	
Урсгал засвар	19238,8	18614,2	624,6	
Томилот, зочны зардал	17001,8	17001,8	0,0	1,9
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6265,7	6023,3	242,4	0,7
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2076,4	2043,4	33,0	
Аудит баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	360,0	360,0	0,0	
Даатгалын үйлчилгээ	294,0	108,6	185,4	
Тээврийн хэрэгслийн татвар	331,6	331,6	0,0	
Тээврийн хэрэгслийн оношилгоо	60,0	55,0	5,0	
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1318,0	1299,0	19,0	
Газрын төлбөр	334,4	334,4	0,0	
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1491,3	1491,3	0,0	
Бараа үйлчилгээний бусад зардал	1200,0	1200,0	0,0	0,1
Хичээл үйлдвэрлэлийн дадлага	1200,0	1200,0	0,0	
Урсгал шилжүүлэг	37798,0	37434,4	363,6	4,1
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	3023,9	2660,3	363,6	
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	34774,1	34774,1	0,0	
Нийт зардал	915612,7	910713,7	0,0	100,0



Төсвийн гүйцэтгэлээр нийт зардлын 69,8 хувийг цалин хөлс болон нэмэгдэл урамшил, 8,4 хувийг ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, 2,5 хувийг тогтмол зардал, 4,2 хувийг хангамж, бараа материалын зардал, 1,8 хувийг нормативт зардал, 6,5 хувийг эд хогшил, урсгал засварын зардал, 1,9 хувийг томилолтын зардал, 0,7 хувийг бусдаар гүйцэтгүүлсэн бараа ажил, үйлчилгээний төлбөр хураамж, 0,1 хувийг бараа үйлчилгээний бусад зардал, 4,1 хувийг урсгал шилжүүлгийн зардал тус тус эзэлж байна.

Нийт батлагдсан төсөвт зардлаас 4,9 сая төгрөг буюу 0,5 хувиар зардал хэмнэгдсэн байна. Харин нэр төрлөөр хэтрүүлсэн хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн ариутгалын зардал, эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгслийн зардал, багаж, техник хэрэгслийн зардлууд байна.

Аудитын явцад зардал хэтэрсэн шалтгааныг судалж үзэхэд дараах байдалтай байна.

- Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн ариутгалын зардал хэтэрсэн нь тус зардлыг төсвийн төсөлд хүрэх хэмжээгээр тусгаж хүргүүлдэг боловч багасаж батлагдаж ирсэн, мөн аймгийн Хилийн 5 боомтод орж ирж буй тээврийн хэрэгслийг хуурай замын болон туулах замын ариутгал халдваргүйтгэл хийдэгтэй холбоотой,
- Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгслийн зардал хэтэрсэн нь МХЕГ-аас тус газрын лабораторид нян судлалын шинжилгээг хэвийн явуулах, 2018 онд итгэмжлэлийн бэлтгэл ажлын хүрээнд бусад зардлын хэмнэлтээс дутагдалтай байгаа шил сав, эм урвалжийн хангалтыг сайжруулах үүрэг өгөгдсөнтэй холбоотойгоор шил сав болон нимгэн үет томографын оношлуур авсан,
- Багаж, техник, хэрэгслийн зардлын төсөв хэтэрсэн нь үндсэн хөрөнгө худалдан авсантай холбоотой байна.

Батлагдсан багаж, техник хэрэгслийн зардлаас 24404,4 мянган төгрөг, урсгал засварын зардлаас 2360,6 мянган төгрөг, нийт 26765,0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг харьяа дээд байгууллагын зохих зөвшөөрөлгүйгээр урсгал зардлаас бэлтгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 42 дугаар зүйлийн 42.7-д “Төсөвт зохицуулалт хийхдээ хөрөнгийн болон урсгал зардлыг хооронд нь шилжүүлэх, төсөвт тусгагдаагүй шинэ хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхийг хориглоно.”, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 86 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 1.2-д “Төрийн өмчит хуулийн этгээд нь эд хөрөнгө олж авах, бүртгэх, худалдах, актлах талаар ирүүлсэн саналыг хянан үзээд энэ журамд заасны дагуу шийдвэрлэж, шийдвэрийг тухайн байгууллагад хүргүүлнэ.”, 2.1-д “Төрийн өмчит хуулийн этгээд нь энэ журмын 1.2-т заасан асуудлыг шийдвэрлүүлэхдээ дор дурдсан бичиг баримтаас тухайн харилцаанд хамааралтай баримт, материалыг бүрдүүлнэ” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Тайлант хугацаанд тус байгууллага нь авлага, өр төлбөргүй ажилласан байна.



III Бүлэг. Дотоод хяналтын үйл ажиллагаа хангалтгүй байна.

3.1. Газрын үйл ажиллагаанд дотоод болон хөндлөнгийн хяналтын тогтолцоо бүрдсэн байна.

Монгол Улсын Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8.4, Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолыг үндэслэн аймгийн Мэргэжлийн хяналтын газрын даргын 2018 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн А/11 дугаар тушаалаар байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийх журмыг баталсан бөгөөд уг тушаалаар дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах багийг 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан байна.

“Байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулах журам”-ын дагуу газрын дотоод хяналт шалгалтын баг нь 2018 онд хяналт шалгалт хийх жилийн төлөвлөгөөг боловсруулан батлуулсан байна.

Хөндлөнгийн хяналтаар аймаг дахь төрийн аудитын байгууллагын гэрээт аудитын компани болох “Шинэ баланс” ХХК-аас тус газрын санхүүгийн тайланд аудит хийж, дүгнэлт, зөвлөмж өгч ажилласан байна.

3.2. Дотоод хяналтын үйл ажиллагаа хангалтгүй байна.

Монгол улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын дагуу аймгийн Мэргэжлийн хяналтын газрын даргын 2018 оны А/11 дүгээр тушаалаар дотоод хяналт, шалгалтын багийг шинэчлэн томилж 17 заалт бүхий жилийн төлөвлөгөө баталсан байна.

Дотоод хяналт шалгалтын багийн 2018 оны ажлын тайланд ажлын гүйцэтгэл 90,0 хувьтай гэж тайлагнасан ч төлөвлөгөөний заалт бүрээр биелэлт гаргаагүй байна.

Дотоод хяналтын ажилтны хийсэн ажлын тайланг байгууллагын Удирдлагын зөвлөлөөр хэлэлцэж, дүгнээгүй байна.

2018 онд дотоод хяналтыг 2 удаа удирдамжийн дагуу хийгдсэн боловч зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн ажлын үр дүнгийн талаар нотлох баримт алга байна.

Дотоод хяналтын төлөвлөгөөний биелэлтийг газрын удирдлагын зөвлөлөөр дүгнэсэн удирдлагын зөвлөлийн шийдвэр, баримтууд байхгүй бөгөөд аудитын явцад биелэлтийг баримтад үндэслэн тооцож үзэхэд 2018 онд 17 төлөвлөгөөт ажлаас 11 ажлыг хийж гүйцэтгэсэн, хэрэгжилт 64,7 хувийн биелэлттэй гарч байгаа нь дотоод хяналтыг хангалтгүй байгааг илтгэж байна.

Тайлант онд Прокурорын газраас зөрчил шалган шийдвэрлэх үйл ажиллагаа хууль, тогтоомжид нийцэж байгаа эсэхийг аймгийн Ерөнхий прокурорын баталсан удирдамжаар 2018 оны 4 дүгээр сард шалгалт хийж 6 зөрчилд зөвлөмж өгсөн байна.

Зөвлөмжийн биелэлтийг аймгийн Прокурорын газарт хүргүүлсэн байна.

Мэргэжлийн хяналтын газрын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг “Шинэ баланс аудит” ХХК баталгаажуулж нийт 1,3 сая төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж,



1 төлбөрийн акт, 1 албан шаардлага өгч ажилласан байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Газрын үйл ажиллагааны төлөвлөгөө, зорилго зорилт бүрэн биелээгүй, байцаагч нарын үйл ажиллагааны үр дүн хангалттай хэмжээнд хүрэхгүй байна.
2. Тус газрын бүтэц, орон тоо нь батлагдсан хязгаараас хэтрээгүй боловч зарим хэлтсийн орон тоо нь илүү болон дутагдалтай байна.
3. Орлогын төлөвлөгөөг хэрэгжүүлж ажилласан байна.
4. Урсгал зардлаас үндсэн хөрөнгө бэлтгэсэн байна.
5. Газрын үйл ажиллагаанд дотоод болон хөндлөнгийн хяналтын тогтолцоо бүрдсэн байна.
6. Дотоод хяналтын үйл ажиллагаа хангалтгүй байна.

Аудитаар нийт 26,7 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлж 2 албан шаардлага, 6 зөвлөмж өгч ажиллалаа.

ДОРНОД АЙМГИЙН
МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗАР21061, Чойбалсан, Дорнод аймаг
Утас/Факс: 7058-4109

2019.06.06 № 01/372

танай _____-ны № _____-т

Г ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Ц.БАТБАЯР ТАНАА

Танай байгууллагаас гүйцэтгэлийн аудитаар
хүргүүлсэн зөвлөмж, албан шаардлагыг биелүүлж,
хэрэгжилтийг хангаж ажиллах болно.

ДАРГА  Д.МӨНХТУЯА

120619616

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг
аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга Д.Мөнхтуяад зөвлөж байна.

1. Хэлтсүүдийн хяналт шалгалтын хамрах хүрээ, төлөвлөгөөт шалгалтуудаас гадна улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй барилга, байгууламж, авто замын ажлуудад төлөвлөгөөт бус хяналт шалгалтын цар хүрээг нэмэгдүүлж, үр дүнг сайжруулах, эрсдэлийг төлөвлөхдөө иргэдийн хүлээлттэй байгаа газар, салбар, объектод анхаарал хандуулж ажиллах.
2. Орон тооны батлагдсан хязгаарыг мөрдөж, төсвийн зарцуулалтын үр ашгийг сайжруулан дутагдалтай орон тоог нөхөж ажиллах.
3. Хүний нөөцийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах.
4. Орлогын төлөвлөгөөг аймгийн ЗДТГ-ын СТСХ-тэй зөвшилцөж бодитой төлөвлөж байх.
5. Хөрөнгө бэлтгэхдээ холбогдох хууль, журмыг баримталж ажиллах.
6. Дотоод хяналтын үйл ажиллагаанаас бий болох үр өгөөжийг нэмэгдүүлэх.



Аудитаар тавигдсан албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, биелэлтийг 2019 оны 11 дүгээр сарын 20-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.


**ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ**

2019 оны 06 сарын 12 өдөр Дугаар 19 Чөлөөтэй хийг

**Гүйцэтгэлийн аудитын тайланг
баталгаажуулах тухай**

Төрийн аудитын тухай хуулийн 13.5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/207 дугаар тушаалын 5 дугаар хавсралтын 2.4 дэх заалт, 2016 оны А/92 тоот тушаалаар батлагдсан "Гүйцэтгэлийн аудитын журам"-ын 12.40 дэх заалт, аймаг дахь Төрийн аудитын газрын удирдлагын зөвлөлийн 2019 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ТУШААХ нь:

1. "Мэргэжлийн хяналтын газрын үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүн, үр нөлөө"-нд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталсугай.
2. Аудитаар тавигдсан албан шаардлагыг хавсралтаар баталсугай.
3. Аудитын тайланг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Л.Хишигтөговх, Мэргэжлийн хяналтын газрын дарга Д.Мөнхтуяа нарт тус тус хүргүүлсүгэй.
4. Гүйцэтгэлийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ахлах аудитор Б.Дэлгэрмаад даалгасугай.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  Д.БАТБЯАР


110419841

Тэргүүлэх аудиторын 2019 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 19 тоот тушаалын хавсралт

Албан шаардлагын жагсаалт

2019.06.12

Nb	Байгууллагын нэр	Гүйцэтгэлийн аудитын дугаар	Албан шаардлагын утга	Мөнгөн дүн
1	Аймгийн МХТ	ДОА-2019/38-ГА	Тушаалын хэрэгжилт хангуулах тухай	
2			Зөрчил арилгуулах тухай	26 765.00
Нийт дүн				26 765.00





ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АЛБАН ШААРДЛАГА

2019 оны 06 сарын 06 өдөр

Дугаар 0/115 - ДОА-2019/38/ГА

Чойбалсан хот

Г Тушаалын хэрэгжилт хангуулах тухай Г

Төрийн аудитын тухай хуулийн 15.2 дугаар зүйлд тодорхойлогдсон Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд дарга бөгөөд Тэргүүлэх аудиторын баталсан төлөвлөгөөний дагуу "Мэргэжлийн хяналтын газрын үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүн, үр нөлөө"-нд хийгдсэн гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ.

Тус газрын нийт орон тоо нь батлагдсан хязгаараас хэтрээгүй боловч Төрийн захиргаа, эрсдэлийн удирдлагын хэлтэст 2, Эрүүл мэнд, боловсрол, хүнсний хяналтын хэлтэс 1 орон тоогоор илүү, Экспорт, импорт, хилийн хорио цээрийн хяналтын хэлтэс нь 11 орон тоо дутуу ажилласан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1 дэх "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5 дахь "Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох;" , МХЕГ-ын даргын 2019 оны А/05 дугаар тушаалыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн аудитын байгууллагын аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4.1-д "..... албан шаардлага өгнө" гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ** нь:

Орон тооны батлагдсан хязгаарыг мөрдөж, төсвийн зарцуулалтын үр ашгийг сайжруулан ажиллаж, албан шаардлагын биелэлтийг 2019 оны 11 дүгээр сарын 20-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга Д.Мөнхтуяад даалгав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

<p>ӨГСӨН¹:</p> <p>АУДИТЫН МЕНЕЖЕР <i>[Signature]</i></p> <p>АХЛАХ АУДИТОР <i>[Signature]</i></p> <p>АУДИТОР <i>[Signature]</i></p>	<p>В.ЦЭНГЭЛМАА</p> <p>Б.ДЭЛГЭРМАА</p> <p>Я.ЗОРИГ</p>	<p>ЗӨВШӨӨРСӨН:</p> <p>АЙМГИЙН МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗРЫН ДАРГА <i>[Signature]</i> Д.МӨНХТУЯА</p>
--	--	---

¹ Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ." гэж заасны дагуу харууцагч албан тушаалтанд харууцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.

110019374



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АЛБАН ШААРДЛАГА

2019 оны 06 сарын 06 өдөр

Дугаар 04/16 дот. 2019/38-1А

Чөлөөт хөт

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-д тодорхойлогдсон Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд аймгийн Мэргэжлийн хяналтын газрын үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүн, үр нөлөөнд гүйцэтгэлийн аудит хийх явцад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Батлагдсан багаж, техник хэрэгслийн зардлаас 24404,4 мянган төгрөг, урсгал засварын зардлаас 2360,6 мянган төгрөг, нийт 26765,0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг харьяа дээд байгууллагын зохих зөвшөөрөлгүйгээр урсгал зардлаас бэлтгэсэн байна.

Төсвийн зардлыг эдийн засгийн ангилал хооронд гүйлгэн зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 42 дугаар зүйлийн 42.7-д "Төсөвт зохицуулалт хийхдээ хөрөнгийн болон урсгал зардлыг хооронд нь шилжүүлэх, төсөвт тусгагдаагүй шинэ хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхийг хориглоно.", Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 86 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 1.2-д "Төрийн өмчит хуулийн этгээд нь эд хөрөнгө олж авах, бүртгэх, худалдах, актлах талаар ирүүлсэн саналыг хянан үзээд энэ журамд заасны дагуу шийдвэрлэж, шийдвэрийг тухайн байгууллагад хүргүүлнэ.", 2.1-д "Төрийн өмчит хуулийн этгээд нь энэ журмын 1.2-т заасан асуудлыг шийдвэрлүүлдэгдээ дор дурдсан бичиг баримтаас тухайн харилцаанд хамааралтай баримт, материалыг бүрдүүлнэ." гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4.1-д "... төрийн аудитын байгууллага холбогдох албан тушаалтанд албан шаардлага өгнө" гэсэн заалтыг үндэслэн ШААРДАХ НЬ:

Хөрөнгө бэлтгэхдээ Төсвийн тухай хууль болон холбогдох журмыг мөрдөн ажиллаж, албан шаардлагын биелэлтийг 2019 оны 11 дүгээр сарын 20-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга Д.Мөнхтуяа, нягтлан бодогч Б.Оюунбат нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨГСӨН:

ЗӨВШӨӨРСӨН:

ХЭЛТСИЙН ДАРГА-БӨГӨӨД АУДИТЫН МЕНЕЖЕР В.ЦЭНГЭЛМАА АХЛАХ АУДИТОР Б.ДЭЛГЭРМАА АУДИТОР С.ЭНХБААТАР

МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗРЫН ДАРГА Д.МӨНХТУЯА НЯГТЛАН БОДОГЧ Б.ОЮУНБАТ

110019370

1 Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "төрийн аудитын байгууллагаас төвшин албан шаардлага, төлбөрийн актыг цаг хувацанд нь биелүүтгээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцаж албан тушаалтанд хариуцаагүй тохиолдолтаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.